89

ӨМНӨГОВЬ АЙМАГ
СЭВРЭЙ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 27 өдөр Дугаар 3/09 Сайншанд

Бохир усны төлбөрийн хэмжээ
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Орон нутгийн өмчит байгууллагын автомашинаар зөөвөрлөх 1 литр бохир усны төлбөрийг айл өрхөд 35 (Гучин таван) төгрөгөөр, аж ахуйн нэгж байгууллагад 45 (Дөчин таван) төгрөгөөр тогтоосугай.

2. Бохир усыг зөөвөрлөх явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллахыг Дэмд-Од орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дарга (Б.Цогнэмэх)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга (А.Пүрэв)-т даалгасугай.

ДАРГА Ч.ОГТБИШ

4625013018